



"ХИШИГ-УУЛ"

ХУВЬЦААТ КОМПАНИ

Улаанбаатар хот. Багануур дүүрэг
Нацагдоржийн гудамж. Ш/Х-228
Утас./Факс: (01-21) 21168, 9999-9498
E-mail:hishiguul@yahoo.com

2025.03.26 № 16
танай _____ -ны № _____ -Т
Г Брокер, дилерийн компаниудад Г

"Хишиг-Уул" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2025 оны 3 сарын 17-ны өдөр хуралдаж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2025 оны 4 сарын 28-ны өдөр зарлан хуралдуулахаар тогтоол гаргасан билээ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.13 дахь хэсэгт заасны дагуу хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Гүйцэтгэх
захирал



Я.Нэргүй



"ХИШИГ-УУЛ" ХУВЬЦААТ КОМПАНИ

Улаанбаатар хот, Багануур дүүрэг

Нацагдоржийн гудамж, Ш/Х-228

Утас: 9999-9498, 9911-5690

Цахим шуудан: director@khishig-uul.com

hishiguul@yahoo.com

Брокер, дилерийн компаниудад

2025.03.26 № 17

танай _____ -ны № _____ -т

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
мэдэгдэл хүргүүлэх тухай

Компанийн нэр:	"Хишиг Уул" ХК
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 2-р хороо, Нацагдоржийн гудамж, Ш/Х228
Хурал хуралдах өдөр, цаг:	2025 оны 4-р сарын 28-ны өдөр, 15:00 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж, Капитрон Банк Төвөр, 6 давхар, Сноу Хилл Консалтанси ХХН
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	ТУЗ ТУЗ-ын хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн санал, шаардлага гаргасан /нэр/ Саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан /нэр/
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2025 оны 3-р сарын 17-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2025 оны 3-р сарын 21-ний өдөр
Бүртгэлийн өдөр:	2025 оны 4-р сарын 8-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2025 оны 3-р сарын 26-ны өдөр
Хүргүүлсэн огноо:	2025 оны 3-р сарын 26-ны өдөр
Хурлын даргын нэр:	Я.Нэргүй
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга: А.Солонго Гишүүн: Э.Анударь
Баримт бичгийн жагсаалт	/Хавсралтаар/
Баримт бичгийн хуудасны тоо:15..... ширхэг
 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН ДАРГА

Я.НЭРГҮЙ

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 03 дугаар сарын 17

№ 01

Улаанбаатар хот

*“Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай”*

Компанийн тухай Хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 69.3, 69.6, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын 2.1, 2.3, “Хишиг-Уул” ХК (“Компани” гэх)-ийн дүрмийн 7 дүгээр зүйлийн 7.32.3-ыг удирдлага болгож, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“ХЭЭХ”)-ыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж, Капитрон Банк Товер, 6 давхар, Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН-ийн байр хаягт хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсүгэй. Үүнд:
 - Нэг.** Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - Хоёр.** Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - Гурав.** Компанийн 2025 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
 - Дөрөв.** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
3. ХЭЭХ-г хуралдуулах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор зохих баримт бичгийн хамт хүргүүлсүгэй.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 8-ны өдөр байхаар тогтоосугай.
5. Хурал зохион байгуулах комисст дараах нэр бүхий хүмүүсийг томилсугай:
 - i. Гүйцэтгэх захирал Я.Нэргүй

- ii. Хуульч А.Солонго
- iii. Хуульч Э.Анударь

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-н дагуу баталж, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн дотор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр, бүртгэл, хаяг нь тодорхой хувьцаа эзэмшигч нарт бичгээр мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлын хүрээнд Компанийн хувьцаа эзэмшигчдийн танилцах боломжтой баримт бичгүүдийн жагсаалтыг, эдгээр баримт бичгийг бэлэн болгох боломжтой хугацааны хамт Хавсралт №2-р тогтоож, ажлын өдрүүдэд 09:00 цагаас 18:00 цагийн хооронд Компанийн байранд хүрэлцэн ирж танилцах эрхтэй болохыг дурдсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Я.Нэргүй, Тооллогын комиссын даргаар А.Солонго, гишүүнээр Э.Анударь нарыг тус тус томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №3-р баталсугай.
10. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2025 оны 04 дүгээр сарын 8-ны өдрийн ҮЦТХТ ХХК-ийн бүртгэлд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн Хавсралт №4-р баталсугай.
11. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, гаргасан дүгнэлтийг Хавсралт №5,6-р баталсугай.
12. Санхүүгийн Зохицуулах Хорооны журмын дагуу саналын хуудсаар санал өгч болох бөгөөд ийнхүү санал өгөх сүүлийн хугацаа нь 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00 цаг хүртэл байна. Саналын хуудасны загварыг Хавсралт №7,8-р баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 03 дугаар сарын 17

№ 02

Улаанбаатар хот

*“Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн
талаарх дүгнэлтийг гаргаж, хувьцаа эзэмшигчдийн
хуралд танилцуулж, батлуулах тухай”*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”, “Хишиг-Уул” ХК (“Компани” гэх)-ийн дүрмийн 7 дүгээр зүйлийн 7.32.3-ийг удирдлага болгож, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хуралдаж ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж, гаргасан дүгнэлтийг Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, батлуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



Д.ГОНГОР

ХИШИГ-УУЛ ХК-ийн
ТУЗ-ийн 2025 оны 03 сарын 17-ны өдрийн
Тогтоолын Хавсралт №1

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР**

“ХИШИГ-УУЛ” ХК (“Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“ХЭЭХ”) нь 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж, Капитрон Банк Товер, 6 давхрын уулзалтын өрөөнд болох тул хувьцаа эзэмшигчид Та бүхнийг хуралдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Компанийн оноосон нэр: ХИШИГ-УУЛ ХК

Бүртгэлийн өдөр: 2025 оны 04-р сарын 08-ны өдөр хүртэл

Хурлаар хэлэлцэх асуудал:

Нэг. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Хоёр. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Гурав. Компанийн 2025 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

Дөрөв. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;

Хувьцаа эзэмшигчид Компанийн байранд ажлын өдрүүдэд 09.00 цагаас 18.00 цагийн хооронд ирж ээлжит хуралтай холбоотой баримт бичиг, тогтоолын төсөлтэй **хурлын комиссын дарга Я.Нэргүй (утас: 99999498, 88180947)-тэй** холбогдон танилцах боломжтой бөгөөд холбогдох мэдээллийг утсаар лавлана уу.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

“ХИШИГ-УУЛ” ХК-ийн
ТУЗ-ийн 2025 оны 03 сарын 17-ны өдрийн
Тогтоолын Хавсралт №2

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ
АСУУДЛЫН ХҮРЭЭНД КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БОЛОМЖТОЙ
БАРИМТ БИЧГҮҮДИЙН ЖАГСААЛТ**

Д.д	Танилцах баримт бичгүүд	Бэлэн болох хугацаа
1.	Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт	Бэлэн
2.	Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт	Бэлэн
3.	Компанийн 2025 оны Бизнес төлөвлөгөө	Бэлэн
4.	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн анкет	Бэлэн
5.	Компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлан	Бэлэн
6.	Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;	2025 оны 4-р сарын 5-ны дотор
7.	Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан журмын дагуу хийсэн эсэх талаарх аудитын байгууллагын дүгнэлт;	2025 оны 4-р сарын 5-ны өдрийн дотор
8.	Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;	Бэлэн

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ
(Хурал 15:00 цагт эхэлж 16:00 цагт дуусах)

№	Дэд хэсэг	Хариуцах эзэн
1	Хурлын ирцийг бүртгэх /тооллогын комисс/	Тооллогын комисс
2	Хурлын ирцийг мэдээлэх /тооллогын комисс/	
3	Хурлын дарга ХЭЭХ-ыг нээж, хурлаар хэлэлцүүлэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	Хурлын дарга Я.Нэргүй
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах Нэг. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай; Хоёр. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай; Гурав. Компанийн 2025 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай; Дөрөв. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай;	Хурлын дарга Я.Нэргүй
6	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	Тооллогын комисс
7	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	Хурлын дарга Я.Нэргүй
8	Хурлыг хаах /хурлын дарга/	

*ХИШИГ-УУЛ ХК-ийн
ТУЗ-ийн 2025 оны 03 сарын 17-ны өдрийн
Тогтоолын Хавсралт №4*

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОХ ЭРХТЭЙ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЖАГСААЛТЫГ 2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ
ӨДРИЙН БАЙДЛААР ҮЦТТХТ ХХК-ИЙН БҮРТГЭЛ ДЭХ МЭДЭЭЛЭЛД ҮНДЭСЛЭН
БАТАЛНА.

**КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦСЭН ДҮГНЭЛТ**

2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор хийсэн ажилд:

№	Хийгдэх ажлууд	Гүйцэтгэл
1.	“Хэрлэн” худалдааны төвийн дээврийн их засварын ажил	70%
2.	Борлуулалтыг өргөтгөх, хэрэглэгчдийг хүнсний өргөн хэрэглээний чанартай бүтээгдэхүүнээр хангах ажлыг гүйцэтгэх	100%
3.	Хэрлэн супермаркетын бараа борлуулалтыг нэмэгдүүлэн байгууллагуудтай гэрээ байгуулан бараа материалыг захиалгаар ханган нийлүүлнэ.	94%
4.	Тэмдэглэлт ой баяруудаар цаг үеийн эрэлт шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүний өргөтгөсөн болон урамшуулалт худалдаа, бэлгийн багц бэлтгэх, захиалгат, хүргэлтийн үйлчилгээг зохион байгуулах	100%
5.	108 м ² гүн хөлдөөх камер шинээр суурилуулах	100%
6.	Орон нутгийн телевиз, мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан зар сурталчилгаа тогтмол явуулж үйл ажиллагаагаа сурталчилна.	Тогтмол явагдсан
7.	Ашиглагдаагүй заал талбайн ашиглалтыг сайжруулан, заалны дүүргэлтийг нэмэгдүүлэх, талбайн ашиглалтыг нэмэгдүүлэх, худалдааны салбарыг нээх	Дээврийн засварын дараа эхлүүлсэн
8.	Жавхлант хэсгийн ашиглагдаагүй байгаа зааланд их засвар хийж, заалыг ашиглалтад оруулах	2025 онд
9.	Барааны орох хэсгийн шат, чулуун хана, шатны гишгүүр, бариул зэргийг шинэчлэн сайжруулах	Биелсэн
10.	Тандир зууханд мах шарж, утах шинэ үйлчилгээ эрхлэх	50%

Хоёр. Ажилчдын нийгмийн бодлого, боловсролд чиглэсэн ажлууд:

№	Хийгдэх ажлууд	Гүйцэтгэл
1.	Ажиллагсдын эрүүл мэндэд анхаарч тэжээллэг хоол унд олгох	90%
2.	Эмчилгээ сувилгаанд хамруулан зардал хөнгөлөлт үзүүлэх	Биелсэн
3.	Эрүүлжүүлэх бясалгалын хичээлд хамруулах	2 удаа хийсэн
4.	Эрүүл мэндийн дасгал сургууль зохион байгуулах	80% биелсэн

5.	Албан хаагчдын хүүхэд залуучуудыг гэрээгээр суралцуулан, сургалтын төлбөрт хөнгөлөлт, хандив үзүүлэх, дадлагажуулах, ажлын байраар хангах	2 хүүхэд
6.	Шаардлагатай ажил мэргэжлийн сургалтад хамруулах	4 хүн сургалтад сургасан
7.	Гэр хороололд амьдардаг ажилтан, албан хаагчдад нүүрс түлээний хөнгөлөлт олгох.	Хөнгөлөлт тусламж үзүүлсэн
8.	Ажиллагсдад тохиолдсон баяр баясгалан, зовлон бэрхшээлийг хуваалцаж санхүү, эд материалын болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх	Биелсэн

Гурав. Дүүрэг болон нийгэм, иргэдэд чиглэсэн ажилд:

№	Хийгдэх ажлууд	Гүйцэтгэл
1.	Дүүргийн аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин зохиогдож буй арга хэмжээг, сургалт сурталчилгааг ойртуулан өөрийн компанийн байранд зохион байгуулж ажилтан албан хаагчид, түрээслэгчдийг хамруулна.	Биелсэн
2.	Харьяалалтай өндөр настан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, тохиолдсон уй гашуу, баяр баясгаланг хамт хуваалцана.	Биелсэн
3.	Харьяа хорооны зорилтот бүлгийн хүүхдүүдэд хандив туслалцаа үзүүлэх. Идэвх, санаачилга гарган ажиллах. 2 хүүхдэд 18 нас хүртэл хадгаламж нээнэ.	Биелсэн
4.	Төрийн ба төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй хүмүүнлэгийн ажилд идэвхтэй оролцоно	Байнга оролцдог
5.	Нийгмийн эрүүл мэндэд анхаарч “Хөдөлгөөн-Эрүүл мэнд” нийтийн цэнгээнт бүжгийг өөрийн компанийн байранд тогтмол зохион явуулна	Биелсэн
6.	Дүүргийн иргэд, хөдөлмөрчдөд үзүүлэх байнгын ажлын байрны тоог нэмэгдүүлнэ	8 хүний ажлын байр нэмэгдсэн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦСЭН ДҮГНЭЛТ

Тус Компани нь 2024 онд 16 гаруй ажиллагсадтайгаар Супермаркет дэлгүүр, ажлын байрны түрээс, зоогийн газар гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Санхүүгийн тайланг санхүүгийн байдал, үйл ажиллагааны орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлан гэсэн 4 төрлөөр бэлтгэж гаргасан ба аккруэл суурьтай, балансын тоон үзүүлэлтүүд нь төгрөгөөр илэрхийлэгдсэн. Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн.

1. Санхүү байдлын тайлангаар

Эргэлтийн хөрөнгө 385,123,073.68 төгрөг, үндсэн хөрөнгө 548,985,357.26 төгрөг, биет бус хөрөнгө 400,000.00 төгрөг, урт хугацаат хөрөнгө оруулалт 459,625,625.25 төгрөг, Нийт хөрөнгийн дүн **1,394,134,056.19 төгрөг** болно.

Урт хугацаат хөрөнгө оруулалт 459,625,625.25 төгрөг байгаа нь үндсэн хөрөнгийн их засварын зардал бөгөөд барилга байгууламж дээр капиталжуулах ёстой.

Дансны өглөг 586,331,158.72 төгрөг, татварын өр 29,210,850.29 төгрөг, НДШ-ийн өглөг 162,530.04 төгрөг байна.

2. Орлого үр дүнгийн тайлан.

Компанийн 2024 онд нийт борлуулалтын орлого 1,504,363,621.54 төгрөгийн борлуулалт хийж, Татварын дараах цэвэр ашиг 69,390,586.53 төгрөгийн ашигтай ажилласан. Борлуулалтын зардал нь 1,019,867,209.61 төгрөг.

Борлуулалтын орлогыг сүүлийн 3 жилийн байдлаар харуулбал.

Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он
Борлуулалтын орлого	1,684,617,204	1,545,276,362	1,504,363,621.54
Нийт ашиг	7,222,166	9,194,852	69,390,586.53

Дээрх хүснэгтээс үзэхэд борлуулалтын орлого нь он онд харилцан адилгүй байгаа нь тухайн үеийн иргэдийн худалдан авах чадвар, нөхцөл байдлаас шалтгаалсан гэж үзэж байна.

Дээрх хүснэгтээс үзэхэд борлуулалтын орлого нь он онд харилцан адилгүй байгаа нь тухайн үеийн иргэдийн худалдан авах чадвар, нөхцөл байдлаас шалтгаалсан гэж үзэж байна.

Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он
Зардал	1,677,395,038	1,536,081,510	1,019,867,209.61

3. Өмчийн өөрчлөлтийн тайлан:

Өмч 86.825,000.00 төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 658.460.091.00 төгрөг, эздийн өмч 83.645.405.00 төгрөг, хуримтлагдсан ашиг (82,598,367.77) төгрөг, Эздийн өмчийн нийт дүн 746,332,128.23 байна.

ХЭЭХ-Д ОРОЛЦОХ ЭРХ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС
ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ КУМУЛЯТИВ АРГААР СОНГОХ
САНАЛ АВАХ “САНАЛЫН ХУУДАС”

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр		
Регистрийн дугаар		
Санал өгөх хувьцааны тоо		
Кумулятив саналын тоо		
ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч		Нийт өгөх саналын тоо
1.	Н.Цэцэнхаан	
2.	Н.Сүндэрьяа	
1.	Я.Нэргүй	
2.	Ц.Роза	
3.	Н.Сүлд-Оргил	
4.	Б.Энххорол	
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч		Нийт өгөх саналын тоо
1.	Д.Гонгор	
2.	Д.Сэржамц	
3.	Ж.Ганболд	

Санамж. Хувьцаа эзэмшигч та Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг кумулятив аргаар саналаа өгөхдөө доорх зааварчилгааг анхааралтай уншина уу. Саналын тоогоо илүү эсвэл буруу өгсөн тохиолдолд таны саналын хуудас хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.

Жишээ нь: “Хишиг-Уул” ХК-ийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 6 гишүүн нь ердийн, 3 гишүүн хараат бус гишүүн байхаар тогтоосон. Хувьцаа эзэмшигч та “Хишиг-Уул” ХК-ийн 100 ширхэг хувьцаа эзэмшдэг бол Таны эзэмшиж буй 100 ширхэг хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд $900 (100 \times 9 = 900)$ ширхэг саналын эрхтэй болно. Та нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно. Эсвэл нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Та саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

Та саналын хуудас бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт саналыг тоог тэмдгийг бичнэ үү.

1. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.
2. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг: _____

Санал авах хуудсыг үйлдсэн огноо: 20... оны ... сарын ... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/ Үгүй

Тооллогын комиссын дарга: _____ / _____ /

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

ХЭЭХ-Д ОРОЛЦОХ ЭРХ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС
ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЖ БАЙГАА АСУУДЛААР
САНАЛ АВАХ “САНАЛЫН ХУУДАС”

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр	
Регистрийн дугаар	
Санал өгөх хувьцааны тоо	

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай			
2.	Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай			
3.	Компанийн 2025 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай			
4.	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгосугай			

Заавар: Та өөрийн саналыг (+) гэж тэмдэглэнэ үү.

Хувьцаа эзэмшигчийн овог нэр, гарын үсэг \..... \

Саналын хуудас үйлдсэн огноо:

Хувьцаа эзэмшигч итгэмжлэлийн үндсэн дээр оролцсон бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл, итгэмжлэлийг хавсаргах:

Овог, нэр:

Гарын үсэг:

Саналын хуудсыг хүчинтэйд тооцсон эсэх (доогуур зурах): Тийм Үгүй

Тооллогын комиссын дарга:

Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

Утас: _____

[Загвар саналын хуудас]

ХЭЭХ-Д ОРОЛШОХ ЭРХ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС
ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ КУМУЛЯТИВ АРГААР СОНГОХ
САНАЛ АВАХ “САНАЛЫН ХУУДАС”

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр		Амар овогтой Бат	
Регистрийн дугаар		ТЖ0000000	
Санал өгөх хувьцааны тоо		1000 ширхэг	
Кумулятив саналын тоо		1000*9сонгогдох гишүүн= 9000	
ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч		Нийт өгөх саналын тоо	
1.	Бат	500	
2.	Гэрэл	1000	
3.	Дорж	500	
4.	Урнаа	500	
5.	Даш	0	
6.	Болор	1000	
7.	Чимэг	2000	
8.	Ням	500	
9.	Хорол	1000	
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч		Нийт өгөх саналын тоо	
Бусад хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн	1.	Оргил	1000
	2.	Цогт	1000
	3.	Номин	-

Хувьцаат компанийн ТУЗ-ийг сонгохдоо кумулятив аргаар санал хураана. Иймд энэхүү аргын талаар дараах тайлбарыг анхаарна уу.

Санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Та саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй. Жич: Та 100 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг гэвэл таны санал өгөх эрхийн нийт тоо $9 \times 100 = 900$ ширхэг байна. Таны нэр дэвшигч бүрд өгсөн саналын тооны нийлбэр нь таны санал өгөх эрхийн нийт тооноос илүү байж болохгүй. Хэрэв илүү гарсан тохиолдолд таны саналын хуудас хүчингүй болно гэдгийг анхаарна уу. Мөн санал авах хуудсыг засварласан балласан тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно. [Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 880 дугаар тогтоолын хавсралт]

Хувьцаа эзэмшигчА.Бат..... Гарын үсэг
Утас: _____ 88909000 _____

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дах хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, “ХИШИГ-УУЛ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.8.3 дахь хэсгийг тус тус удирдлага болгон Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд зохих журмын дагуу холбогдох эрх бүхий төрийн байгууллагуудад хүргүүлж, мэдэгдэхийг Хуульч А.Солонго, Э.Анударь нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Я.НЭРГҮЙ

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

№02

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дах хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, “ХИШИГ-УУЛ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.8.3 дахь хэсгийг тус тус удирдлага болгон Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд зохих журмын дагуу холбогдох эрх бүхий төрийн байгууллагуудад хүргүүлж, мэдэгдэхийг Хуульч А.Солонго, Э.Анударь нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Я.НЭРГҮЙ

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

№03

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дах хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, “ХИШИГ-УУЛ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.8.3 дахь хэсгийг тус тус удирдлага болгон Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2025 оны Бизнес төлөвлөгөөг баталж, цаашид төлөвлөгөөний дагуу Компанийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэн ажилласугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд зохих журмын дагуу холбогдох эрх бүхий төрийн байгууллагуудад хүргүүлж, мэдэгдэхийг Хуульч А.Солонго, Э.Анударь нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Я.НЭРГҮЙ

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

№04

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.5 дах хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, “ХИШИГ-УУЛ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.8.3 дахь хэсгийг тус тус удирдлага болгон Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд доор дурдсан нэр бүхий гишүүдийг сонгож, томилсугай. Үүнд:

Ердийн гишүүд:

1. Я.Нэргүй
2. Ц.Роза
3. Н.Цэцэнхаан
4. Н.Сүндэрьяа
5. Н.Сүлд-Оргил

Хараат бус гишүүд:

1. Д.Гонгор
2. Д.Сэржамц
3. Ж.Ганболд

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд зохих журмын дагуу холбогдох эрх бүхий төрийн байгууллагуудад хүргүүлж, мэдэгдэхийг Хуульч А.Солонго, Э.Анударь нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Я.НЭРГҮЙ

"ХИШИГ-УУЛ" ХК-ийн

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тэмдэглэл

Хурал товлогдсон өдрөө буюу 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 14:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Багануур дүүрэг, Нацагдоржийн гудамж, Хишиг-Уул ХК-ийн байранд хуралдав. Хуралд гишүүд биечлэн болон онлайн хэлбэрээр 66,6%-ийн ирцтэйгээр хуралдлаа.

Хуралд оролцсон гишүүд:

1. Я.Нэргүй
2. Ц.Роза
3. Д.Сэржамц
4. Д.Гонгор
5. Н.Сүлд-Оргил
6. Ж.Ганболд нар оролцов.

ТУЗ-ийн гишүүн Я.Нэргүй хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцууллаа:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах, хурлын тов, хэлэлцэх асуудлын жагсаалтыг батлах тухай;
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайланг хэлэлцэх;
3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;
4. Компанийн 2025 оны Бизнес төлөвлөгөөг хэлэлцэх.

ТУЗ-ийн гишүүн Я.Нэргүй: Юун түрүүнд, Компанийн тухай Хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 76 дугаар зүйлийн 76.1.2, "Хишиг-Уул" ХК ("Компани" гэх)-ийн дүрмийн 7 дүгээр зүйлийн 7.32.3-д заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж, хэлэлцэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15 цагт 00 минутад Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж, Капитрон Банк Товер, 6 давхар, Сноу Хилл Консалтанси ХХН-ийн байранд зарлан хуралдуулах асуудлыг хэлэлцье. Та бүхэнд ямар санал байна?

ТУЗ-ийн дарга Д.Гонгор: Миний хувьд хурлын тов дээр нэмэлт саналгүй.

ТУЗ-ийн гишүүн Н.Сүлд-Оргил: Дэмжиж байна.

Бусад гишүүд мөн татгалзах зүйлгүй гэснээр нийт гишүүдийн зөвшөөрсөн саналаар 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15 цаг 00 минутад Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж, Капитрон

Банк Товер, 6 давхар, Сноу Хилл Консалтанси ХХН-ийн байранд зарлан хуралдуулахаар батлав.

ТУЗ-ийн гишүүн Я.Нэргүй: Миний зүгээс хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэх саналтай байна.

Нэг. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Хоёр. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Гурав. Компанийн 2025 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

Дөрөв. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох.

ТУЗ-ийн гишүүн Я.Нэргүй: Өөр асуудал нэмэх, санал дэвшүүлэх хүн байна уу?

ТУЗ-ийн гишүүн Я.Нэргүй: Өөр асуудал нэмэх хүн байхгүй бол дараах байдлаар хэлэлцэх асуудлыг томъёолъё.

Нэг. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Хоёр. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Гурав. Компанийн 2025 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

Дөрөв. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох.

ТУЗ-ийн хуралд оролцож буй бүх гишүүд санал нэг байна гэснээр 100% саналаар хэлэлцэх асуудлыг тодорхойллоо.

ТУЗ-ийн гишүүн Ц.Роза: Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга, тооллогын комиссыг томилох талаар ярилцъя. Миний санал захирал С.Нэргүй хурлаа удирдаад явах, тооллогын комиссын даргаар А.Солонго, гишүүнээр Э.Анударь нар байх саналтай байна.

ТУЗ-ийн гишүүд бүгд татгалзах зүйлгүй гэснээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар А.Солонго, гишүүнээр Э.Анударь нарыг тус тус томиллоо.

ТУЗ-ийн гишүүн Я.Нэргүй: Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж болон бусад хувьцаа эзэмшигчид, олон нийтэд хүргэх талаар төрийн байгууллагаас тогтоосон журам байгаа тул түүнд нийцүүлэн тогтоох шаардлагатай.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалын жагсаалтыг хэлэлцэх асуудалтай холбоотойгоор дараах байдлаар тогтооё:

Д.д	Танилцах баримт бичгүүд	Бэлэн болох хугацаа
1.	Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт	Бэлэн
2.	Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт	Бэлэн
3.	Компанийн 2025 оны Бизнес төлөвлөгөө	Бэлэн

4.	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн анкет	Бэлэн
5.	Компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлан	Бэлэн
6.	Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;	2025 оны 4-р сарын 5-ны өдөр
7.	Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан журмын дагуу хийсэн эсэх талаарх аудитын байгууллагын дүгнэлт;	2025 оны 4-р сарын 5-ны өдөр
8.	Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;	Бэлэн

ТУЗ-ийн гишүүн Ц.Роза: Би дараагийн хэлэлцэх компанийн санхүүгийн тайланг хэлэлцсэн дүгнэлтийг танилцуулъя.

Тус Компани нь 2024 онд 16 гаруй ажиллагсадтайгаар Супермаркет дэлгүүр, ажлын байрны түрээс, зоогийн газар гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Санхүүгийн тайланг санхүүгийн байдал, үйл ажиллагааны орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлан гэсэн 4 төрлөөр бэлтгэж гаргасан ба аккруэл суурьтай, балансын тоон үзүүлэлтүүд нь төгрөгөөр илэрхийлэгдсэн. Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн.

1. Санхүү байдлын тайлангаар

Эргэлтийн хөрөнгө 385,123,073.68 төгрөг, үндсэн хөрөнгө 548,985,357.26 төгрөг, биет бус хөрөнгө 400,000.00 төгрөг, урт хугацаат хөрөнгө оруулалт 459,625,625.25 төгрөг, Нийт хөрөнгийн дүн 1,394,134,056.19 төгрөг болно.

Урт хугацаат хөрөнгө оруулалт 459,625,625.25 төгрөг байгаа нь үндсэн хөрөнгийн их засварын зардал бөгөөд барилга байгууламж дээр капиталжуулах ёстой.

Дансны өглөг 586,331,158.72 төгрөг, татварын өр 29,210,850.29 төгрөг, НДШ-ийн өглөг 162,530.04 төгрөг байна.

2. Орлого үр дүнгийн тайлан.

Компанийн 2024 онд нийт борлуулалтын орлого 1,504,363,621.54 төгрөгний борлуулалт хийж, Татварын дараах цэвэр ашиг 69,390,586.53 төгрөгийн ашигтай ажилласан. Борлуулалтын зардал нь 1,019,867,209.61 төгрөг.

3. Өмчийн өөрчлөлтийн тайлан:

Өмч 86.825,000.00 төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 658.460.091.00 төгрөг, эздийн өмч 83.645.405.00 төгрөг, хуримтлагдсан ашиг (82,598,367.77) төгрөг, Эздийн өмчийн нийт дүн 746,332,128.23 байна.

ТУЗ-н нарийн бичиг: Ц.Роза гишүүний танилцуулсан энэхүү дүгнэлттэй холбоотой дэвшүүлэх санал байна уу?

ТУЗ-ийн гишүүн Я.Нэргүй: Санал байхгүй. Зөвшөөрч байна.

ТУЗ-н нарийн бичиг: Я.Нэргүй гишүүний танилцуулсан компанийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлттэй холбоотой нэмэлт санал Та бүхэнд байна уу?

ТУЗ-н гишүүн Д.Сэржамц: 2025 онд их хэмжээний хэлцэл, хөрөнгө оруулалт байгаа юу?

ТУЗ-н гишүүн С.Нэргүй: Хувьцаа эзэмшигчдийн хувьцааг эргүүлэн худалдан авахаас бусдаар 2025 онд их хэмжээний хэлцэл, хөрөнгө оруулалт хийгдэхгүй. Хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдан авах санал гаргах хугацаа дуусаагүй байгаа учраас хэр их хэмжээний хувьцаа худалдаж авахыг тооцоолж мэдэхгүй байна.

ТУЗ-н гишүүн Н.Сүлд-Оргил: Нэмэлт санал байхгүй байна.

ТУЗ-н нарийн бичиг: За ойлголоо. Тэгвэл хуралд оролцож буй бүх гишүүд нэмэлт саналгүй, зөвшөөрч байна гэж ойлголоо.

ТУЗ-н нарийн бичиг: Дараагийн ТУЗ-ийн гишүүнийг сонгох асуудлын хувьд ТУЗ-ийн гишүүн Я.Нэргүй нь ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох саналтай байна. Гэхдээ 2024 оны 11 сарын 22-ны өдөр нээлттэй дуудлага худалдаагаар Я.Нэргүй 608,400,000 төгрөгөөр Компанийн нийт 34 хувийн хувьцааг худалдан авахаар шалгарч, улмаар 2024 оны 12 сарын 31-ний өдөр Нийслэлийн өмч хувьчлах комиссоос “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ”-г олгосноор нийслэл Компанийн хувьцаа эзэмшигч байхаа больсон. Иймээс Нийслэлийн Өмчийн Харилцааны Газрын саналаар томилогдсон ТУЗ-ийн гишүүд болох С.Даваасүрэн, С.Сэржжаргал нарыг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, оронд нь Н.Цэцэнхаан, Н.Сүндэрьяа нарыг шинээр сонгох саналыг Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр оруулах саналтай байна.

ТУЗ-ийн гишүүд татгалзах зүйлгүй гэснээр ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох, мөн Н.Цэцэнхаан, Н.Сүндэрьяа нарыг шинээр сонгох саналыг Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр тогтлоо.

ТУЗ-ийн гишүүн Я.Нэргүй: Хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн 100 хувийн саналаар дараах асуудлыг шийдвэрлэлээ.

ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“ХЭЭХ”)-ыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж, Капитрон Банк Товер, 6 давхар, Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН-ийн байр хаягт хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсүгэй. Үүнд:
 - Нэг.** Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - Хоёр.** Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - Гурав.** Компанийн 2025 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
 - Дөрөв.** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
3. ХЭЭХ-г хуралдуулах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор зохих баримт бичгийн хамт хүргүүлсүгэй.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 8-ны өдөр байхаар тогтоосугай.
5. Хурал зохион байгуулах комисст дараах нэр бүхий хүмүүсийг томилсугай:
 - i. Гүйцэтгэх захирал Я.Нэргүй
 - ii. Хуульч А.Солонго
 - iii. Хуульч Э.Анударь
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-н дагуу баталж, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн дотор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр, бүртгэл, хаяг нь тодорхой хувьцаа эзэмшигч нарт бичгээр мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлын хүрээнд Компанийн хувьцаа эзэмшигчдийн танилцах боломжтой баримт бичгүүдийн жагсаалтыг, эдгээр баримт бичгийг бэлэн болгох боломжтой хугацааны хамт Хавсралт №2-р тогтоож, ажлын өдрүүдэд 09:00 цагаас 18:00 цагийн хооронд Компанийн байранд хүрэлцэн ирж танилцах эрхтэй болохыг дурдсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Я.Нэргүй, Тооллогын комиссын даргаар А.Солонго, гишүүнээр Э.Анударь нарыг тус тус томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №3-р баталсугай.

10. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2025 оны 04 дүгээр сарын 8-ны өдрийн ҮЦТХТ ХХК-ийн бүртгэлд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн Хавсралт №4-р баталсугай.
11. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, гаргасан дүгнэлтийг Хавсралт №5,6-р баталсугай.
12. Санхүүгийн Зохицуулах Хорооны журмын дагуу саналын хуудсаар санал өгч болох бөгөөд ийнхүү санал өгөх сүүлийн хугацаа нь 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00 цаг хүртэл байна. Саналын хуудасны загварыг Хавсралт №7,8-р баталсугай.

Дээрх асуудлыг хэлэлцэж дуусаад хурлын дарга хурал хаасныг мэдэгдэв.

Хурал 2025 оны 3-р сарын 17-ны өдрийн 15:30 цагт хаав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн нарийн бичиг:

/С.БАТЧИМЭГ/

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГОНГОР